



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/30

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, “Ажлын хороо байгуулах тухай” аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/600 дугаар захирамжийн 3 дахь заалт, “2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн 15/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилтот жил”-ийн хүрээнд сүү цагаан идээг зөв боловсруулж зах зээлд худалдаалах, хүнсний ногоо тариалах, хуванцар савны хэрэглээг бууруулах зэрэг сургалт зохион байгуулах зардалд 3,695,500 (гурван сая зургаан зуун ерэн таван мянга таван зуу) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 3,695,500 (гурван сая зургаан зуун ерэн таван мянга таван зуу) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын бараа, үйлчилгээний бусад зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.



Н.БАТ-ЭРДЭНЭ